



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/309

Алтай хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.7 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Говь-Алтай аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээ, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 22 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тагнуулын ерөнхий газрын Говь-Алтай аймаг дахь хэлтсээс хийсэн Алтай хотын хүн амын ус хангамжийн эх үүсвэр, цэгүүдийн хамгаалалтын бүсэд аюулгүй байдлын тогтолцоон дахь эмзэг, сул байдлыг илрүүлэх эрсдэлийн үнэлгээгээр аюулгүй байдлын түвшин 0.4 оноо буюу дундаас доош үнэлгээтэй гарсан тул улсын онц чухал объектуудын хамгаалалтын найдвартай байдлыг хангах, гамшиг, ослын мэдээ мэдээллийг шуурхай дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх, эрсдэлийг бууруулах, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх арга хэмжээ авах болон Хууль зүй, дотоод хэргийн сайд Говь-Алтай аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулахад Дотоодын цэргийн 825-р тусгай салбарт дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Дотоодын цэргийн 825-р тусгай салбарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Золжаргал), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР